

“УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛ, САХИЛГА, ХАРИУЦЛАГА”
ОРОН НУТГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ
НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Л.Оюун-Эрдэнэ/

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа

Хүндэт аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороодын Засаг дарга нар аа

Одоогоос нэг сарын өмнө бид аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нартай уулзаж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх сүүлийн нэг бүтэн жилийн хугацаанд хийх ажлаа нарийвчлан хэлэлцэж тохирон, яамдуудтай хамтарч ажиллах гэрээг байгуулсан билээ. Энэ ондоо багтаж тавьсан бүхий л зорилтыг хэрхэн ханган биелүүлсэнээр 2020 оны сонгуулийн өмнө үнэлэгдэх бидний дүн тодорхойлогдох болно. Иймд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг гардан хэрэгжүүлдэг бүх шатны Засаг дарга нартай биечлэн уулзаж, илэн далангүй зөвлөлдөж, сум, дүүрэг, хорооны түвшинд Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх арга, тактикийг тодорхойлох шаардлагатай гэж үзэн, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж байна.

Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байна. Өнгөрсөн онд энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулж, төрийн бүх байгууллага, албан хаагчидтай нэгбүрчлэн уулзаж, үйл ажиллагааны түвшин, чадавхийг үнэлэх ажлыг хийсэн. Дээрх үнэлгээний ажлын үр дүн Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд Улсын их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагаас боловсруулсан 43 дүрэм журам, стандарт зэрэг бодлогын баримт бичигт тусгалаа олсон. Төрийн албаны шинэчлэлийг эрчимтэй, хэлбэрэлтгүй хэрэгжүүлж, зохион байгуулах нь бидний энэ оны ажлын гол зорилт байх болно.

Манай Засгийн газар байгуулагдаж байхад гол нэрийн экспортын бүтээгдэхүүний үнэ бууран, орлого эрс багассаны дээр Засгийн газрын өмнө хуримтлагдсан их хэмжээний өр зээл, асар их алдагдал бүхий улсын төсөв зэрэг олон хүндрэл бэрхшээл тулгарч байсан. ОУВС-тай хамтарч ажиллан, өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд боломжтой бүх зардлыг бууруулах, мөн төсвийн орлогыг нэмэгдүүлэх болон бусад олон арга хэмжээг хэрэгжүүлж ажилласнаар хямралын гол аюул занал холдож байна. Одоо бид бүс нутгийн хөгжил, орон нутгийн бүтээн байгуулалтад илүү анхаарах болно.

2019 онд Улсын төсөвт 3.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь өнгөрсөн онтой харьцуулахад 68.4 хувиар илүү болсон. Төвлөрлийг сааруулж, орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг дээшлүүлэх үүднээс худалдан авах ажиллагаа болон техникийн хяналтыг аймагт шилжүүлэх хүсэлт багагүй гарсны дагуу энэ жил Улсын төсвийн хөрөнгө оруулалтын олон арга хэмжээг аймаг, орон нутгийн мэдэлд шилжүүлж байна. Орон нутагт хөрөнгө оруулалтын

ажил, үйлчилгээ шилжиж ирснээр ажлын байр шинээр бий болох, аж ахуйн нэгжүүдийн орлого, ашиг нэмэгдэх, техник технологио шинэчлэх, татвар хураамж өсөх, иргэд, айл өрхийн чадавхи сайжрах олон боломжийг бий болгоно гэж үзэж байна.

Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарлаж байгаа тул өнөөдрийн зөвлөгөөн дээр иргэдэд хүргэх төрийн үйлчилгээнд гарч байгаа зөрчил дутагдал, түүнийг арилгах арга замын талаар тодорхой яригдах болно. Цаашид төрийн алба, төрийн үйлчилгээ дижитал хэлбэрт шилжин, улам хурдан шуурхай, чирэгдэлгүй, төлбөр хураамжгүй, үнэлж дүгнэхэд хялбар, хүртээмжтэй болоход чиглэгдэнэ.

Өнгөрсөн өвөл харьцангуй дулаан, цас багатай байсан ч зуншлага оройтож, өвс ургамалын гарц бага, хадлан тэжээл дорвитой нөөцөлж чадаагүй, мал ч бүрэн тарга тэвээрэг авч чадаагүй тул хаваржилт хүндэрч магадгүй байна. Ялангуяа сүүлийн 10 гаруй хоногт эрс хүйтэрсний улмаас зарим аймгуудад зудын аюул тулгарч, малын хорогдол нэмэгдэж байна. Иймд хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван гарах, гамшгийн эрсдлийг үнэлж, хамгаалах арга хэмжээг авах, мал төллөлтийг амжилттай зохион байгуулах шаардлагатай байна.

Та бүхнийг орон нутагт тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлж, шийдвэрлэх арга замыг хамтран тодорхойлон, зөвлөгөөний үйл ажиллагаанд идэвхитэй оролцохыг хүсье.

Орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөнийг нээж байгааг мэдэгдье.